

НИГҮҮЛСЛИЙН АЯЛАЛ

АВРАХ

НИГҮҮЛСЭЛ

4 долоо хоногийн хичээл

ДЭН БҮҮН

АВРАХ

НИГҮҮЛСЭЛ

4 ДОЛОО хоногийн хичээл

ДЭН БҮҮН

2024 он

Зохиогчийн эрхээр хамгаалагдсан ©2023 Фаундри
хэвлэлийн газар®

Анхны хувилбар

Аврах Нигүүлсэл

Дэн Бүүн

Энэхүү хэвлэлийг Фаундри хэвлэлийн газар Олон
Улсын Назарын хэвлэлийн газар хамтын харилцаагаар
зохицуулагдсаны дагуу хэвлэв.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү номын аль ч
хэсгийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэх,
хайлтын системд байршуулах, ямар ч хэлбэрт шилжүүлэн
ашиглах- электрон хэлбэрт хөрвүүлэх, олшруулах, дүрс
дуу бичлэгээр хадгалахыг хориглоно. Харин хэвлэмэл
бичвэрт иш татан ашиглаж болно.

Хавтасны загварыг Роб Моначелли

Доторх загварыг Шарон Пэйж

Орчуулсан О.Дөлгөөн

Хянасан С.Бямбасүрэн

Энэхүү номд тусгагдсан интернэт хаяг, цахим шуудангийн
хаяг, утасны дугаар нь энэхүү номыг хэвлэгдэх үед
хэвийн ажиллаж байсан бөгөөд эх сурвалжид тооцож
болно. Фаундри хэвлэлийн газар нь ямар нэг байдлаар
тэдгээрийг батлах, агуулга болон тогтвортой байдалд
хариуцлага хүлээхгүй.

АГҮҮЛГА

1-р долоо хоног
Хүн төрөлхтний эрэл хайгуул

4

2-р долоо хоног
Хориотой үг

20

3-р долоо хоног
Уучлалын хүч

34

4-р долоо хоног
Эвлэрүүлэл

50

1-Р ДОЛОО ХОНОГ

ХҮН ТӨРӨЛХТНИЙ
ЭРЭЛ ХАЙГУУЛ

Би теологийн кинонд дуртай. Теологийн кино гэхээр л Христитгэлийн эсвэл ямар нэг шашны тухай гэсэн үг биш харин Библийн түүхээс тастаж авсан нэг хэсгийн тухай юм. Миний эхнэр “би теологийн хувьд задлан шинжилгээ хийхгүйгээр кино үзэж чаддаггүй” гэдэг. Амьдралынхаа ихэнх цагийг Христийн түүхээс суралцаж, номлож өнгөрөөсөн хүнийхээ хувьд би үзэж харж байгаа бүх зүйлээ энэхүү агуу түүхийн өнцгөөс харж тайлбарлах гээд байдаг хандлагатай болчихож. Киноны дүрүүдийг би юу хайгаад байгаагаа мэдэхгүй ч ямар нэг зүйл эрж хайж буй хүмүүстэй адилтгаж хардаг, гэхдээ эцсийн дүндээ тэд өөрсдийнхөө хүн чанар, нинжин сэлтгэлээ л хайсан байдаг. Тэд хэн байхаар бүтээгдсэнийхээ дагуу өөрсдийнхөө дотор хэрхэн бүрэн дүүрэн амьдрах вэ гэдгээ мэдэхээр хичээсэн байдаг.

Надад зориулсан хувь заяа, дуудлага, зорилго, утга учир байгаа гэсэн бодол бидний сэтгэлийн гүнд бий. Тэгээд тэрхүү амьдралын утга учрын түлхүүрийг олохыг эрэлхийлдэг. Үүнийг би “хүн төрөлхтний эрэл хайгуул” гэж тодорхойлоод байгаа юм. Хүн төрөлхтний эрэл хайгуулын тухай хамгийн сайн харуулж чадсан маш сайн кинонуудын нэг нь “Groundhog day” (Минжний өдөр) юм. Жүжигчин Билл Маррэй АНУ-ын Пенсилваниа мужийн Панкстауни гэх жижигхэн хотод үндэсний хэмжээнд алдартай болсон минжний царайг ил болгох ажилд томилогдож буй сэтгүүлчийн дүрд тоглодог. Тэнд байхдаа Маррэй өдөр болгон нэг л зүйлээ давтдаг амьдралын циклд орно. Өглөө сэрэх болгонд дахиад л Минжний Өдөр...

Өдөр бүрийн нэгэн хэвийн цаг хугацаа, хоосон мэдрэмждээ гацсан байдлаа өөрчилж, маргаашаа утга учиртай болгох гэж байдаг бүх аргаа хэрэглэх боловч юу ч түүний нөхцөл байдлыг өөрчилж чаддаггүй.

Киноны туршид тэр хүмүүстэй уулзах, хүмүүсээс зугтах, хүмүүсийг буруутгах, гомдоох, өөрийгөө зовоох гэх мэт олон арга хэрэглэнэ. Хамгийн сүүлд нь тэр шинэ тактик туршиж үзэхээр шийдэн, үйлчлэхийн баяр баясгалан, өгөхийн сайхан, хөгжим болон урлагт дурлах, хайрлах чадвараа сэргээнэ. Тэгснээрээ маргаашдаа дурлаж сэрэх боломжтой болдог.

=====

**Энэ киног Номлогчийн
Үгс номын орчин үеийн зүйрлэл
гэж ойлгож болохуйц.**

=====

Киноны төгсгөлийн дүгнэлт нь анхнаасаа бидэнд өгөгдсөн байсан нигүүлслийг авах гээд хөөцөлдөж байгаа боловч өөрсдийнхөө утга учиртай гэж харсан зүйлийнхээ араас гүйж байхад ч биднийг хүлээж буй Бурханыг санагдуулдаг. Энэ киног Номлогчийн үгс номын орчин үеийн зүйрлэл гэж ойлгож болохуйц. “Номлогчийн Үгс” (Ecclesiastes) гэдэг нь “номлогч” эсвэл “багш” гэсэн утгатай боловч Еүгин Петерсон номыг орчуулахдаа хэрэглэсэн Хайгуулч¹ (the Quester) гэдэг үгийг яагаад сонгосноо тайлбарлахдаа “бичээсийн (Номлогчийн Үгс) туршлагын хүрээнд түүхийн турш юу хамгийн чухал вэ гэсэн анхдагч суурийг тавих эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дуу хоолой болох гэж энэ үгийг ашигласан” гэжээ. Номын оршил хэсэгт амьдралаасаа өөрсдийнхөөрөө утга учрыг хайх, бий болгох гэсэн эцсийн эцэст хий хоосон, үр дүнгүй байдаг хүний оролдлогын талаар бичжээ.

Номлогчийн үгс нь хий хоосон зүйлийн тухай бичсэн алдартай бичвэр, магадгүй дэлхийн хамгийн алдартай бичвэр байх. Номонд бичигдсэн мэргэн ухаан бидний анхаарлыг татдаг. Туйлын шударга байдлын тухай ч гэсэн анзаарахгүй байхын аргагүй. Нээрээ шүү, хүмүүс бүр үнэхээр анзаардаг. Тэд яагаад анзаардаг юм бол оо! Итгэгч ч бай, итгэгч биш ч бай анзаардаг. Гэхдээ тэдний ихэнх нь Библид энэ тухай бичигдсэнийг мэдээд гайхдаг юм.

Өөрсдийнхөө амьдралаас ямар нэг зүйл олох гэсэн олон хоосон оролдлогуудаа зогсоож, анхаарлаа Бурханд бүрэн өгч, Бурхан гэж хэн болох, биднээр дамжуулан юу хийж чадах вэ гэдэгт анхаарах нь хамгийн чухал бөгөөд хэрэгтэй зүйл гэдгийг Библид заасан. Яг үнэндээ Номлогчийн үгс номд Бурханы тухай тийм ч их бичээгүй. Библийн бусад 65 номд энэ тухай бичээсэй гээд үлдээсэн бололтой. Бичигч үүгээрээ

хүмүүст амьдралын утга учраа өөрсдөө хайж олоод амьдралаа дуусгах ямар ч боломж, чадамж байхгүй гэдгийг ойлгуулахыг зорьсон байх.

Өөрсдийнхөө дураар явах, өөрсдийнхөө арга барил, хүслийнхээ дагуу байх нь бидний сонирхол учраас Номлогчийн үгсийг заавал унших шаардлагатай. Номлогчийн үгс нь бидний сүнсийг “амьдралын хэв маягтай” холбоотой бодол санаанаас цэвэрлэдэг тул Есүс Христээр илчлэгдсэн Бурханы айлчлалд бид бэлэн болох юм. Номлогчийн үгс бол баптисм хүртээгч Иоханы төрлийн ном. Өөрөөр хэлбэл энэ ном нь сүнсний хоол биш. Тэжээл өгдөг биш харин угаадаг ном. Биднийг гэмшилд дууддаг. Цэвэршүүлдэг. Энэ номыг төөрөгдөл, дур хүсэл, шүтээн шүтэх бодол санаанаасаа мөлчийтлөө цэвэршүүлэгдэхийн тулд унших хэрэгтэй. Ингэснээр бид өөрсдийнхөө амьдралыг өөрсдийнхөө аргаар аваад явж чадна гэсэн ихэмсэг, тоомжиргүй сэтгэлгээ болгоноо илчилж, үгүйсгэж байгаа хэрэг юм.²

Еүгин Петерсоний Номлогчийн үгс номын орчуулга ингэж эхэлдэг:

Иерусалим дахь хаан, Давидын хүү, Хайгуулчийн үгс. Утаа, юу ч байхгүй зөвхөн утаа. Юунд ч юу ч байхгүй, бүгд утаа. Насан туршдаа хөдөлмөрлөж, хуруугаа яс болтол зүтгээд юу харуулах гэдэг юм бэ? Нэг үе өөрийн замаар явж, дараагийнх нь ирдэг, гэхдээ юу ч өөрчлөгддөггүй, энэ бол хуучин дэлхийн хувьд ердийн зүйл. Юу байсан, тэр нь байх болно. Юу хийгдэж байсан, тэр мөн л хийгдэх болно. Энэ дэлхийд шинэ зүйл гэж үгүй. Би болбоос “Хайгуулч”, Иерусалим дахь Израилын хаан байсан. Би бүх зүйлийг маш нарийн харсан, дэлхийд болсон бүх зүйлийг судалсан. Би танд хэлье, бичээд байх

зүйл тийм ч алга. Бурхан бидэнд үүнийг амархан байлгасангүй. Би бүхнийг харсан боловч энэ нь юу ч биш утаа, салхинд замхарч буй утаа.

Энэ яаж сайнмэдээ байж чадах юм бол? Номлогчийн үгс номын хамгийн өргөн агуулга бол утга учрыг олохын төлөөх хүний хайгуулын хов хоосон бөгөөд эрээ цээргүй байдлын тухай юм. Зохиогчийн дуртай үг болох Еврейгээр хебел гэдэг үг нь “утаа, манан, уур”, “ихэрхүү зан” эсвэл “утгагүй” гэсэн утгатай. Хебел гэдэг нь ерөнхийдөө тэр нэг зүйлийг л олохын төлөө явж явж, дөнгөж олж хүрээд атгаж авах гээд гараа сунгах төдийд аль хэдийн агаарт замхраад алга болдог гэсэн санааг агуулдаг үг юм. Амьдралын утга учрыг өөрсдөө олох гэж хөөцөлдөх нь атгандаа манан хадгалахтай адилхан. Өнөөдөр энд байх ч маргааш алга болсон байна. Groundhog Day кинотой яг адилхан Номлогчийн үгсийн бичээч нь бид өдөр бүр нэг л зүйлээ давтсаар ямар ч утга учиргүй хэвээрээ сэрдэг гэсэн санааг хэлж байна.

=====

**Хүн төрөлхтний түүхийн турш
тэнгэрлэг салхи буюу амьсгал нь
биднийг сэргээж буй Бурханы үйл
ажиллагаа юм.**

=====

“Наран доор шинэ юм юу ч алга” (эшлэл 9) гэснийг уншаад зарим талаараа бичээчтэй маргамаар санагдаж билээ. Хүн төрөлхтний үйл явцыг нэг л ойлгохгүй байна даа! Биднийг сэрэхэд шинэ кофе байдаг. Автомат жолоодлоготой машин бидэнд бий. Хүний хөдөлгөөн мэдрээд шууд асдаг гэрэл, флаш дээр маань бараг номын сан шиг их ном байгаа. Өдөр бүхэн ямар нэг шинэ юм байж л байдаг! Шинэ зүйлээр хүрээлэгдээгүй цаг гэж хүмүүст үгүй. Тэгсэн ч бид өглөө бүр араас нь хөөцөлдөх, барьж авах, сэтгэлээ дүүргэхийн тулд хэрэглэх ямар нэг шинэ зүйл байгаа гэсэн итгэлтэйгээр сэрдэг. Номлогчийн үгс номд гарч буй бидний найз Хайгуулч нь мөнгө, эрх мэдэл, тааламжтай байдал, мэдлэг, залуу насны араас хөөцөлдөөд тэдгээрийг олж аваад, өөрийн болгоод, хэрэглэсэн боловч дараа өглөө нь манан атгаастай сэржээ. Хүн ямар ч амралтгүй нэг зүйлийн араас хөөцөлдөгч байхаас өөрөөр бүтээгдээгүй юм гэж үү?

Эхлэл 2:7-д “ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг [руах] хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч [нефеш] болжээ” гэжээ. Бидний үүсэл бол бөөгнөрсөн шавар, дэлхийн тоос байлаа. Эхлэл номд хэлснээр Бурхан бидний амьгүй бие дээгүүр сунаж, тэнгэрлэг амьсгалаа хамраар маань үлээсэн. Еврейгээр “амьсгал” гэдэг үг нь “сүнс” эсвэл “салхи” гэдэг үгтэй ижил утгатай. Хүн төрөлхтний түүхийн турш тэнгэрлэг салхи буюу амьсгал нь биднийг сэргээж буй Бурханы үйл ажиллагаа юм. Эш үзүүлэгч нарт тохиолдсон нь ч энэ л зүйл байсан. Баптисм хүртсэн Есүс дээр буусан зүйл бас л энэ байсан. Үйлс номд дээврийн өрөөг дүүргэсэн зүйл бас энэ л байсан. Энэ бол тэнгэрлэг салхи ба амьсгал болох Ариун Сүнс юм. Бурхан амьсгалаа бэлэглэдэг учраас хүн төрөлхтний амьдрал бий болсон.

Би төрөх тасаг болон нас барж буй хүмүүсийн тасагт байж үзсэн. Хүүхэд эхийн хэвлийгээс гарахдаа хамгийн эхлээд агаар амьсгалах гэсэн байгалийн зөнтэй төрдөг. Анхны амьсгалаа авангуут л арьсны өнгө өөрчлөгдөж, уушги томорч, уйлж эхэлдэг. Анхны амьсгал Бурханыг хамар уруу нь үлээхийг хүлээж байсан мэт үргэлж дотогш чиглэлтэй байдаг. Харин нас барж буй хүмүүсийн өрөөнд тахилч нар сүүлийн амьсгалаа авахтай зэрэгцээд талийгаачийн эцсийн амьсгал гардаг. Хэн ч амьсгаа аваад үхдэггүй. Цаг нь дуусахад бид амьсгалаа гаргана. Амьсгал нь түүнийг өгсөн Бурхандаа буцна. Бид араас нь хөөцөлдөж, барьж авсан зүйлээрээ биш, харин Бурханы бэлгээр хамгаалагддаг.

Эхлэл номд Бурхан бидэн рүү амьсгалаа үлээхэд хүн амьд оршигч (Еврей хэлээр нефеш) болсон гэжээ. Нефешгэдэг нь “хоолой” гэсэн утгатай маш сонирхолтой үг. Хоолой бол дотор байгааг гадагшлуулдаг зам бөгөөд хүзүү гэх биеийн маш эмзэг хэсэгт байрладаг. Энэ замаар биднийг амьд байхад хэрэгтэй ус, агаар, хоол гэх бүх зүйл дамждаг. Нэг ёсондоо хүн бол явдаг өлсгөлөн, ярьдаг цангаа, өвддөг хэрэгцээ юм. Бид нар бие даасан бус харин хэрэглээ шаарддаг бүтээлүүд. Хүн байна гэдэг нь эмзэг, хэрэглээ шаарддаг, хамааралтай, хүсэн тэмүүлдэг, өлөн, хэврэг байна гэсэн үг. Ground-hog Day кинонд гардаг шиг бид дотроо дүүргэхийн тулд мөнгө, албан тушаал, алдар нэр, эрх мэдэл, секс, магтаал сайшаал, сайхан бие галбир, анхаарал гэх мэт бүхий л зүйлийн араас хөөцөлддөг. Бид бол хүсэж тэмүүлсээр байдаг оршигчид юм.

Христэд итгэгчид заримдаа хүний хэрэгцээний мөн чанарыг мартаж, сайнмэдээ тунхаглахдаа хүмүүсийг хүслээ буруутгах, дарах эсвэл үгүйсгэхийг шаарддаг. Хүсэж тэмүүлэх нь хүний мөн чанарт байдаг тул бид

тэгж чадахгүй. Юм хүсдэгт маань асуудал байгаа юм биш харин юу хүсдэгт маань байна. Бурханаас тусгаар амьдрах үед бидний хүсэл буруу тийш эргэж, дотогшоо чиглэж, өөрийгөө л аврах эрэл хайгуулд төвлөрч эхэлдэг.

Билл Маррэйгийн тоглосон Боб яасан гэж? (What about Bob?) гээд эртний нэг киноны тухай ярьж л даа. Энэ удаа Маррэй бүх төрлийн айдастай, сэтгэцийн өвчтэй, байж болох бүх л асуудалтай Бобын дүрд тоглодог. Тэр бол зүгээр л явдаг бүтэлгүйтэл байлаа. Тэрээр хүний бүхий л асуудлыг шийдэх Нярайн алхам (Baby Steps) номын зохиолч, өөрийгөө засалч гэж тодорхойлсон Др.Лео Марвин гэх мэргэжлийн зөвлөгчид хандана. Түүний үйлчлүүлэгчид асуудал дундаасаа бүрэн дүүрэн рүү алхах нярайн алхам хийх хэрэгтэй болдог байлаа. Боб Др.Марвиныг шинэ найдвар гэж харан наалдана. Тэгээд Др.Марвин гэр бүлийн аяллаар явахад Боб хаашаа явах гэж байгааг нь мэдэх гэж заль гаргадаг. Боб амралтын газарт очоод төв зам дахь дэлгүүрээс гарч ирэх Др.Марвинтай тааралдана. Тэр Бобыг гэр бүлд нь зүй бусаар саад учруулсан хэмээн зэмлэж, гэртээ харь гэдэг. Харин Боб өвдөг сөгдөн миний харж байсан хамгийн хүн шиг үйлдлийг хийдэг. Тэр зүгээр л “Та надад хэрэгтэй байна. Хэрэгтэй байна. Хэрэгтэй байна” гэж хэлдэг. Хүн байна гэж үүнийг л хэлээд байгаа юм.

Жон Уэслигээс бүх цаг үеийн хамгийн төгс бүтээл юу вэ гэж асуухад тэрээр “Ганцхан Бурхан л Өөрөөрөө дүүргэх боломжтой хоосон орон зай” гэжээ. Бид зөвхөн амьдралыг л Бурханаас махан биеийн амьсгалаар бэлэг болгон хүлээн авах чадвартай бүтээгдсэн биш, мөн аврах нигүүлслийг ч бэлэг болгон хүлээн авахаар бүтээгдсэн юм. “Буга усны урсгалуудыг хүсэхийн адил Миний сэтгэл, Бурхан, Таныг хүсдэг. Миний сэтгэл

Бурханаар, амьд Бурханаар цангадаг” (Дуулал 42:1-2). Нэг магтаалд: “Тоос шороо шиг хэврэг хүүхдүүд, зуурдын зүйлс шиг сул дорой боловч Түүнд найдвал бид бүтэлгүйтэхгүй. Таны өршөөл ямар зөөлөн, эцсээ хүртэл тууштай вэ! Бидний Бүтээгч, Золигч, Найз.”³ гэсэн байдаг.

ЗАЛБИРЦГААЯ

Таныг тэнгэрлэг амьсгал болон амьдралыг хүлээн авах чадамжтай бүтээсэнд Бурханд өөрийнхөө үгээр талархлаа илэрхийлээрэй. Бурханаас бүрэн хамааралтай гэж хэлээрэй. Эмзэг, гачигдалтай хүн чанараа хүлээн зөвшөөрөөрэй.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. “Боб яасан гэж?” киноны төгсгөлд Боб амьдралаа бүрэн дүүрнээр олж, харин Бобд туслахын тулд маш их зүйл хийсэн сэтгэл засалч Др.Марвин сэтгэл мэдрэлийн тасагт номхотгогч цамцтайгаар дуусдаг. Энэ төгсгөл юу хэлэх гээд байна гэж та бодож байна?

2. Манай дэлхий хүн төрөлхтний насан туршийн эрэл хайгуултай юугаараа/яаж төгс зохицсон юм бол?

3. Хүний гэх эрэл хайгуул дунд гацсан хүнд та аврах нигүүлслийг хэрхэн тайлбарлах вэ?

4. Бидний араас нь хөөцөлддөг мөнгө, секс, эрх мэдэл, анхаарал, амжилт гэх мэт бүх зүйл яагаад хэзээ ч хангалттай дүүрдэггүй юм бол?

5. “Чоно үүрэндээ өлзийтэй” гэж ямар утгатай вэ? Энэ нь аврах нигүүлсэлтэй ямар холбоотой юм бол?

ТЭМДЭГЛЭЛ

2-Р ДОЛОО ХОНОГ

ХОРИОТОЙ ҮГ

Дээр үед “секс” гэдэг үгийг шивнэж хэлдэг байлаа. Олон нийтийн газар ховор хэрэглэгддэг хориотой үг байсан юм. Харин одоо цаг өөрчлөгдөөд энэ үг бараг бүхий л хэлбэрээр хаа сайгүй байдаг болж. Секс гэдэг үг хэлж болохгүй үг байхаа больжээ. Энэ үгийг өөр үгээр орлуулаад, хэрэв хэрэглэхээр бол шивнэж эсвэл аажуухнаар хэлнэ. Тэр үг нь гэм нүгэл. “Гэм” гэж олон нийтийн газар чангаар ярих нь нисэх онгоцны буудал дээр “тэсрэх бөмбөг” гэж хэлж байгаатай яг адил. Хүмүүст маш тухгүй байдал үүсгэх тул хүмүүс тан уруу сонжсон эвгүй харцаар харах байх. Тийм учраас бид хэлдэггүй! Харин бүдрэл, алдаа, буруутал, сул тал, зөрчил, шүүлтийн алдаа, дутагдалтай тал, өөсэвгэх мэт үгээр орлуулдаг. Хэрэв гэм гэдэг үг эртний зарим өвчин шиг байсан бол дэлхийд хэрэглэгдэхгүй болох байсан биз. Эсвэл бид энэ үгийг хэлэхгүй байх шийдвэрийг гаргах байсан байх. Гэхдээ хамгийн сүүлийн байдлаар шалгахад бид Еден цэцэрлэгт амьдраагүй учраас гэм нүгэл бидний дунд байсаар байна.

Танаас нэгхэн цагийн зайтай газар хэн нэгэн эхнэр эсвэл нөхрөө хуурч, сэжигтэн зугтааж, хулгайч хулгайлсаар, улс төрчид худлаа хэлж, тамирчид гүйцэтгэл сайжруулах эм бэлдмэл хэрэглэж, сурагчид хуулж, даатгалын компани нөхөн төлбөр өгөхөөс зайлсхийж, үйлдвэрлэгчид бохирдол үүсгэж, мөрийтэй тоглоомд донтож, номлогч итгэлийг урвуулан ашиглаж, цуглааны гишүүн Бурханы аравны нэгийг өөртөө хадгалж, барилгачин булангаас нь хороож байна. Заримдаа эдгээр зүйлс мэдэгддэг бол заримдаа зүгээр л хивсэн доогуураа шүүрдэж оруулаад нуучихдаг. Гэхдээ эдгээр үйлдлийн талаар ярихдаа гэм гэдэг үгийг хэрэглэдэг хүн ховор. Гэм бол шинэ хориотой үг болжээ.

Яг үнэнийг хэлэхэд гэм гэдэг үг өөрөө их бөөрөнхий

барьцгүй үг. Яг нарийн тодорхой тодорхойлолт гаргахад хэцүү. Грек болон Еврей хэлэнд гэмийг илэрхийлсэн бараг хорин өөр үг байдаг. Утгын хүрээнд авч үзвэл хууль бус байдал, буруутай байдал, зөрчил, санаатай буруу үйлдэл, хүслээрээ хийсэн бослого, тэмдэглэгээг орхигдуулах, шударга бус байдал гэх мэт маш олон Библийн ухагдахууныг агуулдаг. Теологичид ирвэсийн толбоноос ч олон төрлийн гэм байдаг гэж үзсэн ба эдгээр нь төрөлх гэм, хувь хүний гэм, нийтийн гэм, хүсэж хийсэн гэм, эрх мэдлээ хэтрүүлсэн гэм, дотоод гэм, туйлын гэм, жижиг гэм, мэдээгүйгээс болж үйлдсэн гэм, үхэлд хүргэх долоон гэм гэх мэт. Ирээдүйд гэмийн төрөл зүйл хомсдолд орохоор юм шиг харагдахгүй байгаа биз дээ. Жагсаалтад алийг нь оруулах, алийг нь оруулахгүй байх дээр саналаа нэгтгэхэд бидэнд нэлээд хүндрэлтэй байсан. Учир нь хэн нэгэнд гэм гэж тооцогдох зүйл нөгөөд нь үгүй байх жишээтэй.

=====

**Теологичид ирвэсийн
толбоноос ч олон төрлийн гэм
байдаг гэж үзсэн.**

=====

Дэлхий гэмийн эсрэг албан тушаалыг хүртэл бий болгосон. Сурган хүмүүжүүлэгчдийн хувьд гэм гэдэг нь үнэт зүйлийг тодруулах, гэгээрүүлэх олон төрлийн сургалт байдаг бол биологичид гэмийг бидний төрөлхийн генд салшгүйгээр холбогдсон байдаг гэж үздэг. Улс төрчдийн хувьд гэм бол нийгмийн тогтолцоо бөгөөд зөв хүмүүсийг сонгож, зөв хуулийг хэрэгжүүлснээр шийдвэрлэж болно гэж үздэг. Цагдаа нарын хувьд гэм бол хууль болон тушаалтай эсрэгцэн тулгардаг харанхуй тал юм. Сэтгэл зүйчдийнхээр гэм нь бидэнд өгөгдсөн ойлгогдохуйц, урьдчилан таамаглаж болохуйц зүйл ба өөрийгөө илүү таньж мэдэх, магадгүй засал, эмчилгээ хийлгэх ч шаардлагатай болдог зүйл. Нийгмийн шударга ёсны удирдагчид жагсаал цуглаан, энэрлийн үйлчлэл, шинэчлэлийг эсэргүүцдэг зүйлийг гэм гэж үздэг. Ёс суртахуунч үзэлтнүүд сайхан дүр үзүүлж, хуваалцаж, эерэг зүйлийг дадлагажуулан, Опрагийн хэлснийг хийснээр гэмийг шийдэж болно гэж үздэг. Телевизийн номлогч нарын хувьд гараа зурагт дээрээ тавих эсвэл мөнгө явуулж, өөрсдийнхөө гайхамшгийг тунхагласнаар гэмээ шийдчихдэг. Сурталчилгааныхны шинэ бүтээгдэхүүний худалдан авалтаар гэм сарних жишээтэй. Эдгээр аргуудын зарим нь хэрэгтэй, зарим нь үгүй.

Бид тэгэхээр яг яах ёстой юм бол? Яг энэ асуулттай тэмцэлдэж буй нэг найзыгаа бид Дуулал 32-р бүлгээс харж болно.

Алдаа зөрчил нь уучлагдсан бөгөөд
Нүгэл нь далдлагдсан нэгэн юутай ерөөлтэй вэ!
ЭЗЭНд гэмтэн гэж үл тооцогддог бөгөөд
Сүнсэндээ заль мэхгүй хүн юутай ерөөлтэй вэ!
Би дуугүй байхад
Өдөржингөө ёолсноос болж яс минь яйрсан.
Учир нь өдөр шөнөгүй

Таны мутар намайг хүндээр дарж байв.
 Шим шүүс минь зуны ганд хатсан юм.
 Би нүглээ Танд хүлээн хэлсэн бөгөөд
 Гэм нүглээ би нуугаагүй.
 “Би ЭЗЭНд алдаа зөрчлөө хүлээнэ” гэж би хэлэв.
 Тэгээд Та миний нүглийн бурууг уучилсан билээ.
 Тиймээс бурханлаг хүн бүр
 Таны олдох боломжтой үед
 Танд залбираг.
 Үнэндээ их ус үерлэхэд тэд түүнд хүрэхгүй.
 Та бол миний хоргодох газар,
 Та намайг зовлон бэрхшээлээс хамгаалдаг.
 Та намайг авралын дуугаар хүрээлүүлдэг.
 Дуулал 32:1-7

Дуулаач гэмээ дотроо хадгалах нь бидний биеийг
 ялзруулдаг гэжээ. Гэм бидний ясыг идэж, өдөр бүр
 өөрсдийнхөө замаар гашуудахад хүргэдэг маш хүнд
 ачаа бөгөөд үерт автаж, сүйрэл рүү урсаж байгаа мэт
 болгодог. Тийм ч учраас дуулаач нь өөрийн гэмийг
 нууснаас хүлээн зөвшөөрсөн нь дээр хэмээн үзэж,
 Эзэнд алдаа зөрчлөө хүлээсэн юм. Үр дүн нь баяр
 хөөр, уучлал, аврал юм. Нөгөө хориотой үг Бурханы
 аврах нигүүлслийн оршихуй дотор шударга илчлэлт
 болж өөрчлөгдлөө. Хэрэв бид гэм нүглийнхээ бодит
 байдлыг хүлээн зөвшөөрөхгүй бол ямар ч шийдэл олж
 чадахгүй. Дахин босгогдох болно гэсэн итгэлтэйгээр
 гэмээ улайн, өгч чаддаг газар бол Бурхан юм. Хэрэв
 аврагдахыг хүсэж байгаа бол гэмийн хэллэгийг сэргээх
 хэрэгтэй.

**Хэрэв бид гэм нүглийнхээ
бодит байдлыг хүлээн
зөвшөөрөхгүй бол ямар ч
шийдэл олж чадахгүй.**

Би гэмийн тухай маш даруугаар илэрхийлсэн нэгэн хүчтэй теологийг санал болгоё. Зарим нь өөрөө бардам, эрдүү, гэмтэй хэрнээ гэмийг буруушаадаг, яг л Ариусгагдсан Доромжлол-Оскар гэж байгаа юм шиг сонсогдохоор тайлбарладаг. Харин бусад нь энэ үг хүмүүсийг тухгүй болгодог учраас хэрэглэхээ больсон. Нью Йорк Таймс сонины нийтлэлч Дэвид Брүүк ингэж бичжээ.

Олон газар, маш олон тохиолдолд гэмийг өөрсдийнхөө хүслээс болж дайн зарлах, мөн түүнчлэн бэлгийн амьдрал, зугаа цэнгэлийг эрүүл таашаал гэж тунхаглахдаа хэрэглэдэг байсан. Гэм бол аз жаргалгүй, цензургүй амьдралын шалтгаан гэсэн утгаар хэрэглэгддэг байв. Хэзээ нэгэн цагт хэн нэгэн өөртөө дуртай байхаа больчих юм шиг байсан тул өөртөө ханагчид болон хуурай-зүрхтнүүд энэ үгийг урвуулан ашиглах болсон юм. Гэвч бодит байдал дээр гэм гэдэг үг байхгүй байж болохгүй. Амьдрал өөрөө тэр чигээрээ ёс суртахууны асуудал учраас бидний сэтгэхүйн салшгүй нэг хэсэг нь гэмийн тухай ойлголт байх ёстой. Гэм бидний мөн чанарт жигнэгдэн болж, үе дамжсаар амьдардаг. Бид бүгд гэмт хүмүүс.⁴

Брүүкийн зөв. Хүний байгаа байдлын тухай ярих гэж байгаа бол “гэм” гэдэг үг заавал хэрэг болно. Гэхдээ гэм бидний гэрт ч бас байдгийг санаж даруугаар ярих хэрэгтэй. Номын төгсгөлд Брүүк гэм нь хайрын үнэнч байдлыг сулруулдаг гэж Уэслийн хэлсэнтэй маш ижил нэг санааг гаргаж ирсэн байдаг. Дотогшоо чиглэсэн аминч үзлийн хайр бидэнд байгааг гэм илтгэдэг. Өөрөөр хэлбэл энэ нь биднийг болон хайртай хүмүүсийг маань сүйтгэж байдаг өөрийн эрх дархат байдал, өөрийгөө хууран мэхэлж байгаа хэлбэр, өөрийгөө өмөөрөх байдал гэх нэг ойлголтод зангидагддаг зүйл юм.

Барбара Браун Тэйлор бичихдээ:

Номлогчид индрийн араас хүмүүсийн нэрийг гэмийнх нь хамт цохон дууддаг байсан үе ард үлджээ. Тэдэнд тийм эрх мэдэл байхгүй болсон. Миний итгэж байгаагаар, тэдний хийж чадах зүйл бол гэмийн үйлс ба үр дагаврыг маш сайн тайлбарласнаар хүмүүс өөрсдийнх нь амьдралд гэмийн шинжтэй зүйл байна уу гэдгийг олж харан, ингэснээр өөрсдийгөө буруутай байдлын ужиг эх үүсвэр эсвэл угаасаа ийм муу чанартай гэдгээ батлах биш харин хувийн болон нийтийн амьдралдаа өөрчлөлтийг эрэлхийлэх явдал юм. Ямар нэг зүйл буруу байна, үүнийг засах хэрэгтэй гэдгийг бидэнд мэдрүүлдэг ганц найдвар бол гэм. Надад тусламж хэрэггүй гэж бат итгэдэг хүмүүст туслах ямар ч арга байхгүй. Буруу, гажуудсан зүйл юу ч алга гэж нотлох гэж зүтгэдэг хүмүүсийг засах ямар ч найдвар байхгүй. Мөн ямар ч өөрчлөлт гарах боломжгүй, засаршгүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн хүмүүст найдвар гэж байхгүй.⁵

Авралын төлөө хориотой үгийг намуухан өнгөөр хэлэх цаг нь болсон байх. Сайнмэдээний хамгийн цөм утга бол хүмүүс гэмээ улайх тэр мөчид л аврах нигүүлсэл олддог ба ингэснээр Бурхан авардаг юм!

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их бодоосой гэж хүсэж байгаа бол? Бурхан танд юу хэлж байна вэ?

[illegible]

ЗАЛБИРЦГААЯ

Өөрийнхөө залбирлыг бичихийн оронд Нийтлэг Залбирлын Ном-д гэмээ илчлэн хүлээн зөвшөөрсөн дараах хэсэгт анхаарлаа хандуулъя.

Бүх зүрх, бүх хүсэл өмнө нь нээлттэй байдаг, юуг ч нуух боломжгүй Гайхамшигт Бурхан минь, бидний Эзэн Христээр дамжуулан Таныг төгс хайрлаж, Таны ариун нэрийг зохистойгоор алдаршуулахын тулд зүрхний минь бодлыг Өөрийн Ариун Сүнсээр цэвэрлээч. Амен.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Та гэмийг юу гэж тодорхойлох вэ?
2. Найзуудтайгаа уулзаж байхдаа “Та нарынхаар гэм гэж юу вэ?” гэж асуувал яах бол?
3. Бид яагаад “гэм” гэдэг үгийг хэрэглэхээс зайлсхийдэг болсон юм бол?
4. Бид гэмийг хүний зүрхэнд л байдаг хувийн ба ажил хэргийн тогтолцоонд байдаг ил гэм гэж мэднэ. Өнөөгийн нийгэмд алийг нь тодорхойлоход илүү амархан байна?
5. Гэмээ улайх тухай та хэр сайн мэдэх вэ, мөн та хэр их улайдаг вэ?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

3-Р ДОЛОО ХОНОГ

УУЧЛАЛЫН ХҮЧ

Бидэнд хэрэгцээ байгаа гэдгээ хүлээн зөвшөөрч “Өдөр тутмын минь талхыг өгөөч” гэж залбирахдаа бид жинхэнэ хүн шиг байдаг. Мөн, гэмээ улайж, өөрийнхөө бурууг болон уучлуулах хэрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрөх хүсэлтэй байвал бүр илүү жинхэнэ хүн шиг болдог. Уучлалт гуйж байгаа нь өөрсдийгөө даруу болгож байгаа хэрэг юм. Ингэснээр уучлах эсвэл уучлахгүй байх эрх бүхий Нэгэний хайр энэрлийн өмнө бид өөрсдийгөө аваачдаг. Хэрэв бид гэмээ улайвал Тэр итгэмжит байж, биднийг уучилна гэдгээ баттай мэдүүлсэн. Аврах нигүүлсэл бол уучлах нигүүлсэл юм.

Их Эзэний заасан залбиралд зөвхөн “бидний өрийг уучлаач” гэж байсан бол амархан байх байсан гэж би боддог. Гэвч “бид өртөнгүүдээ уучилсны адил” гэж байгаа. Тэгэхээр энэ нь бид бусдыг уучлах хүртэл Бурхан биднийг уучлахгүй гэсэн үг үү? Бид хэн нэгнийг уучилснаар Бурханаар уучлуулах боломжтой болж байна гэсэн үг үү? Үйлдсэн бүх буруу үйлдлээ ширдгэн доогуураа чихэж хаячихаад, юу ч болоогүй мэт яваад өгвөл Бурхан биднийг уучлахгүй гэсэн үг үү? Уучлалын талаарх буруу ойлголт Бурханы шударга байдлыг ихээхэн гажуудуулдаг. Уучилна гэхээрээ л гэмт үйлдэлд хилэгнэхээ больж гөлийсөн болно гэсэн үг биш. Бурханы Хаанчлалыг өөрсөд дундаа авчиръя гэж байгаа бол Библийн дагуух шударга байдал хамаатай хэвээрээ шүү.

Уучлагдсан байх, уучлах гэсэн ойлголтыг харцгаая. Хэрэв хэн нэгэн таны талаар худлаа яриад, танаас хулгайлаад, таныг ашиглаад, хүчиндээд, хуураад, санаатайгаар таныг шархлуулаад гэх мэт байж болох гэмүүдийг таны эсрэг үйлдсэн гэж бодъё. Эзэний заасан залбирлаар бол бид зүгээр уучлаад л юу ч болоогүй юм шиг цаашаагаа яваарай гэж байна уу? Үгүй.

=====

**Уур хилэн биднийг аливааг
тоохгүй орхих байдлаас ангид
байлгадаг бол уучлал харилцааг
сүйрэл рүү биш харин сэргэлт рүү
чиглүүлдэг.**

=====

Бид дээрэлхүү хүн, бүдүүлэг эсвэл зэрлэг догшин хүнийг уучлах тухай бодохоосоо өмнө уурлах нигүүлсэл байгаагийн төлөө Бурханд талархах хэрэгтэй. Бурхан нигүүлслийг ингэх гэж байлгаагүй гэсэн бодит явцуу бодлоосоо салах цаг болжээ. Сайхан сэтгэл гаргаж, юу ч болоогүй юм шиг авирлах нь хохирсон болон хохирол учруулсан хүний аль алинд нь ямар ч ашиггүй. Энэ нь Бурханыг Өөрийнхөө хүссэнээр амар тайван тогтооход саад учруулдаг. Уучлалын эхний алхам бол буруу зүйл тохиолдсон ба үүнд миний уур хүрээд байна гэдгээ хүлээн зөвшөөрөх юм.

Паул Ефесчүүдэд хандан “Уурласан ч, нүгэл бүү үйлд” (4:26) гэснийг уншихдаа би их тайтгардаг. Энэ нь надад тохиолдсон зүйлийн талаар чин сэтгэлээсээ цухалдаж болно гэсэн зөвшөөрөл юм. Энэ бол сайн уур, гэмийг буруу гэж уурладаг уур, Библийн дагуух зөвт байдлын төлөөх уур бөгөөд үл тоохын оронд нүүр тулахыг илүүд үздэг уур юм. Бид уурлаад л болчихдог биш харин уур бухимдлын өнцгөө бидэнд буруу хийсэн хүний сайн сайхны төлөө зөв болгон өөрчилснөөр уучлалын зүг алхаж чадна. Уур хилэн биднийг аливааг тоохгүй орхих байдлаас ангид байлгадаг бол уучлал харилцааг сүйрэл рүү биш харин сэргэлт рүү чиглүүлдэг.

За одоо арай илүү ахисан түвшний зүйл ярья. Хэн нэгнийг уучлахдаа бид тэр хүний зөвхөн юу хийснийг нь өршөөдөг гэж бодохгүй байна. Бид гэмшихгүй л бол Бурханы уучлалыг мэдрэх боломжгүй. Уучлал нь аврах нигүүлслээс урсан гардаг ба загалмай дээр болон Есүсийн амилалтаар гүйцэт болгогдож бүрэн дууссан үйлдэл юм. Хэрвээ бид гэмших л юм бол Тэр бидэнд итгэмжит хандаж биднийг уучилна. Бурхан уучлах шийдвэрийг аль эрт гаргачихсан, уучлалаа аль хэдийн бидэнд өгчихсөн, аль хэдийн уучлахад

бэлэн байрлалаа авчихсан, уучилна гэдгээ бидэнд амлачихсан. Харин бид гэмээ улайж, (“гэмших” гэдэг нь шууд утгаараа эргэж өөр зүг рүү алхах гэсэн утгатай) өөрчлөгдөх зориулалт гаргахгүй бол Бурханы уучлалыг мэдэрч чадахгүй. Биднийг гомдоосон хүн буруугаа хүлээн зөвшөөрч уучлалт гуйхаас нааш бид жинхэнээсээ уучилдаггүйтэй адил.

Би эхнэр Дэнисээ анх үнссэнээ санаж байна. Бидний харилцаа дөнгөж нахиалж байсан хэд хэдэн болзооны дараа байсан юм. Би түүнийг үнсэж байна гэж мөрөөддөг, найддаг байсан үе. Би бүр угаалгын өрөөнийхөө толины өмнө бэлтгэл хийдэг байсан гээд бод доо. Инээдтэй байгаа биз. Үнсэлт 2 хүний оролцоотойгоор бий болдог зүйл. Нэг ёсондоо “Би үнсэхэд бэлэн байна” гэсэн хөдөлгөөнийг зөв зүг рүүгээ хийх ёстой. Харин нөгөө нь адил санаатай байж үнсэхийг хүлээн зөвшөөрч эсвэл адил чиглэлд хөдлөхгүй бол үнсэлт байхгүй. Бүрэн дүүрэн мэдрэмж авах, хоёулаа тааламжтай байхын тулд хоёр хүний оролцоо хэрэгтэй.

Хэдийгээр бид уучлахад бэлэн байсан ч биднийг гомдоосон хүн уучлалын үнсэх хөдөлгөөн хийхгүй, харилцааг сэргээх боломж гаргахгүй бол уучлал бүрэн хэрэгжихгүй. Энэ нь биднийг гомдоосон хүнийг буруугаа хүлээх хүртэл нь түүний эсрэг хорсол тээж өршөөхгүй байна гэсэн үг үү? Үгүй. Бурхан уучилдаг учраас бид уучлах ёстой. Өөрөөр хэлбэл бид зүрх сэтгэлдээ уучлахад бэлэн байрлалаа авсан байх ёстой гэсэн үг. Бид таагүй байдал үүсгэгчийг тархины шорондоо байлгаж өөрсдийнхөө шүүлтийн өмнө ирэхийг хүлээнэ гэсэн үг биш. Бид уур хилэнгийнхээ гал дээрээ тэднийг утахаа нэгэнт больсон. Тэднээр бурууг нь хүлээн зөвшөөрүүлэх гэж оролдох, уучлалт гуйгаагүйнх нь төлөө үзэх ядах гэх мэтээр өөрсдөдөө

байнга тээж явахаа аль хэдийн больсон. Харин Бурханы шударга байдал биеллээ олохын тулд бид тэдэн рүү эргэх ёстой. Бид ч гэсэн Бурхантай адилхан уучлахад бэлэн зогсож байх хэрэгтэй. Өшөө авах болон уучлах нь Бурханы ажил. Биднийг гомдоосон хүн жинхэнээсээ уучлалт гуйхаас ч өмнө хэрэв бид уучлах гэж байгаа бол энэ нь бид Бурханыг шударга, өршөөнгүй гэдэгт итгэж, зохистой гэж үзсэнийхээ дагуу тэдгээр хүмүүст ч тийнхүү хандахыг зөвшөөрч, тэднийг Бурханд өгч байна гэсэн үг юм.

Бурхан өгөөмрөөр уучлагч учраас Христитгэлт бид ч мөн уучлахыг хүсдэг амьдралаар амьдрахаар дуудагдсан. Тэгж байж бид цаашаа явж чадна. Тухайн асуудал болон хүнийг Бурханд өгөхгүй бол бид атаа хорсол, гомдол, үзэн ядалт дотроо хоригдсоор байх болно гэдгийг мэддэг учраас тодорхой нэг асуудал болон хүнийг Бурханд өгдөг. Бусдаас шарх авах нь аймшигтай муухай мэдрэмж ч гэсэн хэн нэгнийг уучлах чадваргүйгээсээ болоод өөрсдийгөө шоронд хорих нь түүнээс ч долоон дор. Бид ачаа дарамтаа Христэд өгдөг. Хэрэв бид уучлаад сурчихвал 50кг ачааг 50км-ын турш үүрч ууланд алхчихаад ачаагаа буулгаж байгаатай яг адилхан хөнгөрнө.

Бурханаар уучлагдах болон бусдыг уучлах хоёрын хооронд өөр бас нэг холбоо бий. Матай номд Их Эзэний заасан залбирлын дараа уучлалын тухай бичээст: “Учир нь, хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн уучилна. Харин хэрэв та нар хүмүүсийг уучлахгүй бол Эцэг тань мөн та нарын алдааг уучлахгүй” (Матай 6:14-15) гэдэг. Энд юу гэж хэлэгдсэн байна? Заримдаа нэг эшлэлийг ойлгохын тулд өөр нэг эшлэл унших нь хамгийн сайн арга болдог.

Матай 18-д Петр Есүсээс хүнийг хэдэн удаа уучлах

ёстойг асуудаг. Түүгээр ч барахгүй их өгөөмөр байна гэж ойлгогдохуйцаар долоон удаа юу гэж Есүсийн хариултад санал дэвшүүлдэг. Библид гардагчлан долоогийн тоо нь бүхэл, бүрэн дууссан төгс тоо учраас хангалттай байж болох байх. Ямар уужим сэтгэлтэй юм бэ гэж Есүс өөрийг нь магтана гэж бодсон байх. Тэгсэн чинь “Пан!” Есүс тоог нь улам нэмдэг! Долоон удаа биш, харин долоог дал дахин эсвэл зарим орчуулга дээр дал дахин долоо гэсэн. Аль нь ч байсан энэ нь долоогоос илүү л байна гэсэн үг. Гэхдээ Петрийн асуусан асуултад тоогоор биш дараах сургаалт зүйрлэлээр хариулдаг. (эшлэл 23-35)

Энэ хэсэгт хаан өөрт нь өртэй хүмүүстэй тооцоо хийхээр шийдэн, дуудаж байгаа тухай гардаг. Арван мянган талантын өртэй нэгэн түүн дээр ирдэг. За хэдүүлээ жоохон тоо бодоодохье. Тухайн үеийн нэг талант гэдэг нь арван таван жилийн бүтэн цагийн цалинтай тэнцүү байсан. Тэгэхээр энэ хүн зээлсэн зоос болгоноо буцааж төлөхийн тулд 150,000 жил ажиллаж байж зөвхөн хүүгүй цэвэр өрөө дарахаар болж байгаа юм. Энэ сургаалт зүйрлэлийг сонссон хүн математикийн тооцооллын хувьд энэ хэмжээний өр төлөгдөх боломжгүй гэдгийг шууд ойлгоно. Бараг улсын нийт баялгаас ч их хэмжээний өртэй байсан гэсэн үг. Одоогийнхоор бол АНУ-ын үндэсний хэмжээний өртэй адилхан гэсэн үг. (хэдэн триллион)

=====

**Заримдаа нэг эшлэлийг
ойлгохын тулд өөр нэг эшлэл
унших нь хамгийн сайн
арга болдог.**

=====

Хаан түүний өрийг хэлэхэд боол нь ийм хэмжээний мөнгө байхгүй бөгөөд төлж чадахгүйгээ хэлдэг. Хаан маш хүйтнээр, бараг нүүр рүү нь ч харалгүйгээр “Түүнийг хорь. Эхнэр, хүүхэд, гэр, агуулах гээд түүнийх гэсэн бүхнийг зараад өрөнд нь суутга. Үлдсэн өрөө барагдуултал нь шоронд хий. Дараагийн хүнийг оруул” гэж харуулдаа хэлсэн байх. Энэ нь оновчтой бөгөөд шударга шийдвэр юм. Тэр өртэй боловч төлж чадахгүй байгаа. Хааны шийдвэр бол шударга.

Гэвч нөгөө хүн өвдөг сөхрөн унаж хаанд “Намайг тэвчин хүлцэнэ үү. Би танд бүгдийг буцааж төлнө” (эшлэл 26). Грек хэлээр түүний гуйж байгаа зүйл нь макродүмөсөн. Орчуулах юм бол “тэвчээртэй хандаач” гэсэн утгатай. Нэмэр болж чадахааргүй байсан ч тэр дахиад хугацаа өгөхийг хүссэн. Харин хаан зарцыг өрөвдсөн, бүх өрийг нь тэглэсэн, чөлөөлж явуулсан гэх гурван итгэмээргүй зүйлийг хийдэг.

Бурхан биднийг бусдыг хэдэн удаа уучлаасай гэж хүсэж байгааг ойлгуулахын тулд Петрийн асуултад хариулт өгөх гэж Есүс энэ сургаалт зүйрлэлийг ярьж эхэлснийг санаарай. Тэнгэрийн хаанчлал бол сургаалт зүйрлэл дэх төлж чадахгүй өрийг тэглэж буй өршөөнгүй хаантай адилхан гэж Есүс хэлсэн. Аврах нигүүлсэл нь бидний төсөөлснөөс ч илүү байдаг өршөөнгүй Бурханы тухай бид мэднэ. Түүний тухай бичээст

“ЭЗЭН бол өрөвч, нигүүлсэнгүй,

Уурлахдаа удаан болоод хайр энэрлээр элбэг баян.

Тэр үргэлж тэмцэлдэхгүй,

Уураа ч мөнхөд хадгалахгүй.

Тэр бидний үйлдсэн нүглийн дагуу бидэнд хандаагүй,

Бидний гэм буруугийн дагуу бидэнд хариу өгөөгүй.” (Дуулал 103:8-10) гэснийг бид мэднэ.

Есүс дагалдагч нартаа зориулан өршөөнгүй

Эцэгийг бидэнд дүрслэн хэлж өгч байгаа боловч заримдаа дүрслэл нь бүх зүйлийг илчилж чаддаггүй. Гэрийн маань ил галын хэсэгт манай гэр бүлийн зураг байдаг. Гэр бүлийн дөрвөн хос, найман ач зээ гээд нийт арван долоон хүний зураг бий. Байшингийнхаа арын талбайд намар авахуулсан зураг юм л даа. Бид их чөлөөтэй хувцасласан байгаа. Би дөнгөж Теннессигийн Титанууд хөл бөмбөгийн тэмцээнээс ирсэн тул жинсэн өмд, тамирын цамц, цагаан оймс, теннисийн гуталтай, газар зүгээр л хөлөө завилаад суучихсан байгаа. Миний цагаан оймс зурган дээр тодоос тод гарахаар байсанд эхнэр Денис минь дургүй байсан юм. Тэгээд цагаан оймсоо нуухын тулд би газар унасан навчийг хөлөө тойруулаад овоолсон. Гэхдээ ганцхан миний цагаан оймс л нуугдсан юм биш. Зургийн цаана бас хүүхдийн угж, соск, саравчтай малгай, живх гээд олон зүйлийг аав ээжүүдийнх нь ард нуусан. Замбараагүй бүх л зүйлийг нуусан.

Энэхүү сургаалт зүйрлэлээс дэлхий дээр асар их баялагтай хааныг бид амархан дүрсэлж чадахаар байгаа биз. Хэрэв зарц нь төлж чадахгүй бол хаан зүгээр өнгөрөөхгүй. Тэр яг л хамар дээрээ үхрийн эвэртэй урт Кадилак машиндаа суугаад, өөрийн эзэмшлийн 1000 га газар уруугаа очоод хүндхэн байдалд буй түрээслэгч фермертээ хандан “Би чиний газар тариалан эрхэлдэг энэ жижигхэн газрыг чамд өглөө” гэж зарлачихаад наран шингэх зүг хүлгийн жолоо залж буй газрын тосны магнат шиг. Техасийн газрын тосны магнатын энэхэн зэргийн өгөөмөр зан түүнд нэг их гарзтай биш, түүнд бараг ямар ч өөрчлөлт мэдэгдэхгүй дээ.

Зогс! Бурханыг ингэж битгий төсөөлөөрэй. Аврах нигүүлсэл хэмээх нөмрөгийн цаана Хааны загалмайн сорви, уучлалын төлөөс нуугдсан байдаг юм. Энэ утга санаа сургаалт зүйрлэл дээр илт ойлгогдохуйц биш

байгаа ч Бурхан гэж хэн бэ гэдгийг харуулсан чухал дүрслэл юм. Тийм ээ, Бурхан өгөөмөр, Түүнд өгөөмөр хандах олон зүйл байдаг ч энэ нь Бурханы өгөөмөр нигүүлслээс юу ч гардаггүй гэсэн үг биш.

Хаан өрийг нь тэглэдэг. Зарцыг чөлөөлж явуулдаг. Бүгдээрээ уучлагдсан зарцыг юу хийх нь үү мөрөөр нь дагая л даа. “Харин өнөөх зарц гадагш гараад, өөрт нь зуун денарын өртэй байсан анд болох нэгэн зарцыг олж хараад” (Матай 18:28а) /Хэрэгтэй тайлбар: энэ хэсэгт тусгагдсан өрийн хэмжээ (зуун мөнгөн зоос, зуун денар гэх мэт орчуулгаас хамаарна) нь арван доллартой арай гэж тэнцэнэ/ “барьж авч хоолойг нь боон, “Өрөө төл” гэв. Харин анд нь болох тэр зарц сөхрөн унаж, түүнээс гуйн “Намайг тэвчиж хүлцээч. Чамд бүгдийг төлнө” гэжээ. Харин тэр үл хүсэн, явж түүнийг өр ширээ төлтөл нь шоронд хаяв” (эшлэл 18:28-30).

Та энэ залуугийн найз баймааргүй байна уу? Тэр яг л өртэй хүн шиг, өрөө төлөх ёстой хэвээр байгаа юм шиг бусад хүнд ч тэгж хандаж байна. Энэ түүхийн хамгийн гунигтай хэсэг нь тэр уучлагдаж өршөөгдсөн хүн шиг үйлдэл гаргаагүй. Магадгүй хааны үгийг буруу сонссон байж болох юм. Магадгүй түүний макродүмөсон-тэвчээртэй хандаач-гэж гуйсан гуйлтынх нь хариуд өр төлөх хугацааг нь сунгасан гэж ойлгосон байх. Тэр ах дүүгээ хоолойноос нь багалзуурдан жаахан хугацаа өгчихвөл төлчихөөр арван доллар эсвэл өөр ямар нэг зүйлийг шаарддаг. Энэ буруу үйлдлийг нь зөвтгөж болох юм. Дөнгөж түрүүхэн хааны өөрт нь үзүүлсэн энэрлийн тусгал болохын оронд бушуухан, шударга ёсыг түргэвчилдэг.

Дараа нь юу болсныг харъя. “Анд зарц нар нь болсон явдлыг хараад ихэд гутарч, эзэндээ очиж, болсон бүгдийг мэдэгджээ. Тэгтэл эзэн нь түүнийг дуудаад

түүнд “Ёрын муу зарц, чи надаас гуйсан тул би бүх өрийг чинь хэлтрүүлсэн. Би чамайг өршөөсний адил чи бас анд чинь болох тэр зарцыг өршөөх ёстой байсан бус уу?” гээд ихэд хилэгнэн уурлаж, өр ширээ бүгдийг төлөх хүртэл нь түүнийг зандалчинд тушаажээ. (эшлэл 31–34).

Уучлахаас татгалзах нь хүн төрөлхтний хамгийн том тамлаан, тарчлаан юм. Энэ бол өөртөө оногдуулсан ял, шорон. Хаан өрнөөс нь хэлтрүүлэхэд тэр бараг юу ч өгөхгүй яваад өгдөг. Их Эзэний заасан залбиралд тусгагдсан зөвхөн уучлагдсан хүний л төлж чадах өр түүнд үлдсэн байв. Уучлагдсанахаа төлөө Бурханд төлөх ёстой зүйл бол Түүнтэй адил байх, Түүний тусгал болох, өөрөө хэрхэн уучлагдсаны адил бусдыг уучлах. Бидэнд уучлал хэрхэн ирж, хэрхэн үлгэрлэн үзүүлэгдсэний дагуу бусдыг уучлахад бэлэн байрлалаа эзэлж, Бурхантай адил байж, Түүний тусгал болохын тулд бид Бурханы Сүнсээр хүчирхэгждэг.

ЗАЛБИРЦГААЯ

Хүмүүс таныг хэрхэн шархлуулсныг өөрийнхөө Бурханд болон бусдад хийсэн буруутай үйлдэлтэй харьцуулан Бурханд хандан залбирлаа бичээрэй. Өөрийгөө Бурханд өртэй гээд төсөөлөөд үз. Таны Бурханаар уучлагдсан нь та бусдыг уучилсны тусгал болж байна уу?

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Биднийг шархлуулсан хүмүүсийн эсрэг гэм хийхгүйгээр уурлах боломжтой юу?

2. Бурхан таныг уучилсныг та бусдыг уучлахдаа дуурайж чаддаг уу?

3. Уучлал болон аврах нигүүлсэл юугаараа холбоотой вэ?

4. Бурхан таны үйлдсэн гэмийг хэрхэн тэсвэрлэдэг гэдгийг ойлгоход хүмүүсийн таны эсрэг үйлдсэн гэм танд хэр тус болдог вэ?

5. Уучлал ба аврах нигүүлсэл нь яагаад чөлөөлөлттэй холбоотой вэ? Уучлагдсан хүний дотор юу болдог бол?

ТЭМДЭГЛЭЛ

4-Р ДОЛОО ХОНОГ

ЭВЛЭРҮҮЛЭЛ

Бид нигүүлслийг Бурханы бэлэг гэж бодох даруйд үүнийг маш олон хэлбэрээр ирдгийг ухаарах болно. Бидэнд угтал нигүүлсэл хэрэгтэй гэдгийг мэдэхээс ч өмнө үргэлж байсаар ирсэн, Бурханы эрэн хайдаг нигүүлсэл юм. Энэ бол биднийг аврах нигүүлсэл рүү хөтөлдөг бэлэг. Угтал нигүүлслийг хүлээн авахад аврах нигүүлслээр дамжуулан Бурхантай харилцах боломжтой болдог. Библид аврах нигүүлслийн бэлгийг тодорхойлох маш олон зүйрлэл бий.

Аврах нигүүлсэл бол байхгүй амьдралаас Христ доторх амьдрал уруу дахин төрж байгаатай адил юм.

Аврах нигүүлсэл бол гэмийн дарангуйллаас чөлөөлөгдөж байгаатай адил.

Аврах нигүүлсэл бол гэр бүлтэй болж үрчлэгдэж байгаатай адил.

Аврах нигүүлсэл бол Бурханы Хаанчлал гэх шинэ улсын иргэн болж байна гэсэн үг юм.

Аврах нигүүлсэл бол Түүний энэрлийн үйлсээр зөвтгөгдөж байна гэсэн үг юм.

Аврах нигүүлсэл бол төлж чадахгүй их өрнөөсөө цагаатгагдаж байгаатай адил.

Аврах нигүүлсэл бол хөндийрсөн нэгэнтэйгээ эргээд эвлэрч байгаатай адил юм.

Аврах нигүүлсэл нь замын голд явж байгаад эргээд эсрэг зүг рүүгээ явах тухай юм.

Аврах нигүүлсэл бол найдваргүйгээр төөрсөн байхдаа олдохтой адилхан.

Аврах нигүүлсэл бол яг л гэртээ ирж байгаа юм шиг.

Аврах нигүүлсэл бол цэвэрлэдэг ванн.

Аврах нигүүлсэл бол шинэ эхлэл.

Аврах нигүүлсэл нь амьдралд шинэ нөхцөл бүхий шинэ харилцааг бий болгож буй шинэ гэрээний хэлцэлтэй адил юм.

=====

**Эвлэрүүлэл бидний
Бурхантай харилцах харилцааг
сэргээн босгодог.**

=====

Христ доторх бидний шинэ амь нь амьдралыг маань эмхэлж цэгцлэн, өөрчилдөг энэхүү бэлгийн хэчнээн гайхалтай болоод үзэсгэлэнтэйг харуулдаг тул зүйрлэлүүдийг энэ мэтээр үргэлжлүүлээд байж болно. Аврах нигүүлслийн цаана буй Библийн нэг чухал утга бол эвлэрүүлэл билээ. Бидний өмнөөс нүглийг уучлан, харилцааг эвлэрүүлж буй энэхүү золиос нь Бичээсийн үндсэн утга юм. Энэ бол бидний гэм уучлагдаж, хир буртаг маань цэвэрлэгдэж, Бурхан биднийг Өөртэйгөө ойртуулж буй үйлдэл юм. Эвлэрүүлэл бидний Бурхантай харилцах харилцааг сэргээн босгодог.

Коринтчуудад хандсан 2-р захидалдаа Паул ингэж бичжээ.

- “Христийн хайр биднийг албаддаг. Учир нь Нэг нь бүгдийн төлөө үхсэн тул бүгд үхсэн гэж бид ятгагдсан. Тэрээр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд, амилуулагдсан Түүний төлөө амьдрах ёстой” (5:14–15).
- “Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна! (эшлэл 17).
- “Учир нь Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, тэдний гэм бурууг эс тооцсон” (эшлэл 19a).
- “Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм.” (эшлэл 21).

Энэ хэллэг нь Хуучин Гэрээний тахилын тухай ойлголтоос улбаатай. Харин Шинэ Гэрээнд өмнө амьтан золиосолдог байсан зүйл одоо Есүсийн үхлээр эцсийн удаа хийгдэж биелэлээ олж буй тухай ярьж байгаа юм.

- “Нэг нь үхсэн” гэдэг нь сүмийн тахилын ширээн дээр олон нүглийн төлөө нэг амьтнаар тахил

- өргөдөг байсныг илэрхийлж байгаа юм.
- “тэдний гэм бурууг эс тооцсон” гэдэг нь гэмийн төлөөсийн үйл явцыг илэрхийлж байгаа юм.
 - “Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир” гэдэг нь гэм буруутай хүмүүсийн өмнөөс гэм зэмгүй амьтныг золиосолж буй бодит байдал.
 - Зөвт болгогдсон гэдэг нь өөр нэгний үнэнч өргөлөөр дамжуулан биднийг зөв харилцаанд сэргээх Бурханы бэлэг юм.
 - “хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!” гэдгээр Бурхантай харилцах шинэ харилцаа болон гэмийнхээ төлөө өргөж буй золиосыг илэрхийлж байна.

Хуучин Гэрээний үеийн өргөл, тахилууд нь гэрээний дагуу харилцаагаа хадгалах, босгон байгуулахын тулд хүмүүсийн гэмийг үүрүүлэхээр Бурханаар тогтоогдсон арга хэрэгсэл байсан. Өргөл бол тэд хэрхэн гэмшиж, гэм нүглээсээ Бурхан уруу эргэж байгаагийн илрэл байсан. Өөрсдийн хийсэн гэмийнхээ төлөө хариуцлага хүлээсэн, Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хийсэн буруутай зүйлийнхээ төлөө өр төлөөс төлсөн гэдгээ мэдүүлж буй хэлбэр байсан. Бохирдсон харилцаа зөвтгөгдөж, нийгэм хэрхэн дахин цэвэршүүлэгдсэнийг үүгээр харуулдаг байлаа. Бусадтай харилцах харилцаа болон Бурхантай харилцах харилцаагаа хэрхэн сэргээсний илэрхийлэл байсан. Гэмт хүмүүсийн дунд Ариун Бурхан оршин байх боломж олгож буй гэрээний хэрэгжилт байсан. Хэдийгээр энэ нь тахилчаар дамжуулан хийгддэг хүний үйлдэл байсан ч тахил өргөж байгаа хүний үйлдэл нь гол биш харин өөрчлөлтийг хийхийн тулд тахилыг хүлээн авч байгаа Бурханы үйлдэл нь хамгийн гол нь байсан юм. Тахил бол Бурханы аврах нигүүлслийн зам юм.

Тахилын системийн хамгийн өндөр агшин нь Эвлэрүүллийн өдөр байсан. Тэр нэгэн өдөр Израйлчуудын мэдсэн, мэдээгүй, санаатай, санамсаргүй үйлдсэн бүх гэм цагаатгагдсан юм. Нэг л өргөлөөр дамжуулан хүмүүсийн бүх гэм Бурханы өмнө аваачигдан уучлагдсан. Жил бүр ард түмэн цугларч, тэргүүн тахилч бүх хүний төлөө эвлэрүүллийн тахил өргөдөг байв. Есүсийн амилалтын дараах дагалдагчид (зарим дагалдагчид нь Есүсийг ирэхээс ч өмнө Бурханыг дагадаг байсан гэдгийг мартаж болохгүй) Левит номыг уншиж байхдаа Эвлэрүүллийн өдрийн төлөө Есүс цовдлогдсон гэдгийг ойлгож эхэлсэн. Бид Шинэ Гэрээнээс эрт үеийн эвлэрүүллийн үйлдэлтэй шууд холбоотой дөрвөн ойлголтыг харж болно.

=====

**Хайртай л бол харахад
хэцүү байсан ч нүүр
буруулдаггүй.**

=====

Ойлголт 1: Төлөх ёстой өр

Бидний ихэнх уламжлалт магтаалын дуунд Есүс бидний өрийг төлж, гэмийг халхлан, уучилсны хариуд бидний өгч чадахгүй зүйлийг бидэнд санал болгодог тухай тусгасан байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ, бас юу гэсэн үг биш вэ гэдэгт анхаарал хандуулах нь чухал. Учир нь үүнд эвлэрүүллийн онолын тухай олон агуулга багтсан байгаа. Нэг нь “шийтгэлийн ханамж” буюу Бурханыг ширүүн ууртай, уучлалынхаа төлөө төлбөр шаарддаг гэж үздэг. Өөрөөр хэлбэл гэрлийн чийдэн хагалсныхаа төлөө нэг нь зодуулах л болж дээ гэж хэлээд хэн нэгнийг урагш гарч цохиулахыг хүлээж буй ууртай эцэг эхтэй адилхан юм. Эцэгийг ингэж дүрслэх нь хайрын Бурхан бидний төлөө золиос гаргасныг мартахад хүргэдэг. Бурхан биднийг Өөртэйгөө эвлэрүүлэхийн тулд Өөрөө Христ дотор байсан юм. Энэ нь биднийг хариу барихыг хүлээж буй Бурханы дүрслэл биш харин бидэнд хариу барих боломж олгохын тулд Өөрөө хөдөлдөг Бурханы тухай дүрслэл.

Төлөх ёстой өртэй холбоотой өөр чухал өвөрмөц ойлголт болох эвлэрүүлэл нь “бидний гэмийг халхалдаг” тухай юм. Үүнийг бид гэмээ Бурханаас нуух, халхлах утгатай хэмээн дандаа буруу ойлгодог. Харин Ариун Бурхан гэм тээж яваа нэгнийг устгахгүйгээр гэмийг өнгөрөөж чаддаггүй гэсэн санааг агуулдаг. Зарим нь загалмай дээрх Хүүгээ орхисон Эцэгийн тухай тайлбарлахдаа Ариун Бурхан гэмийг харж чадахгүй байсан учраас дэлхийн гэмийг үүрсэн Есүс рүү нуруугаа харуулсан гэдэг. Энэхүү тайлбарын нотолгоо нь Есүсийн загалмай дээр хэлсэн Дуулал 22-т гардаг Бурхан минь, Бурхан минь, юунд Та намайг орхисон бэ? гэсэн залбирал юм. Гэхдээ Есүс яагаад ингэж хэлснийг өөр, олон янзаар тайлбарладаг. Хүү нь гэмийг Өөртөө тээсэн учраас Эцэг нь нүүрээ буруулсан гэж үү? Би төрөх өрөөнд шинэ хүнээ хүлээн авч буй эцэг, эхчүүдтэй байж үзсэн бөгөөд хүүхэд нь биеийн гажигтай, эрүүл мэндийн асуудалтай төрлөө гээд хайртай хүүхдээ

хаяж байсан эцэг эхийг харж байгаагүй. Хайртай л бол харахад хэцүү байсан ч нүүр буруулдаггүй. Хэрэв Бурхан хайр юм бол Тэр бас нүүр буруулахгүй ээ.

Есүсийн цус бидний гэмийг Ариун Бурханы нүднээс далдалдаг бүтээлэг шиг учраас Бурхан биднийг харахдаа гэмийг нь хардаггүй гэж хүмүүс хэлж байхыг сонссон. Гэмийн тухай “цусаар хучигдсан” гэсэн утгатай дуу хүртэл бий. “Нүднээс нуух” гэдэг үг “халхлах” гэдэг үгийн нэг утга мөн боловч энэ нь гэмтэй холбоотой Библийн утга биш. Бурхан бидний гэмийг хардаг. Бурхан бидний гэмийг Өөрийнхөө хараанаас нуух гээд байгаа юм биш харин биднийг гэмээс маань цэвэрлэх гээд байгаа юм. Бидний гэмийг халхалдаг цус гэх ойлголт нь хэн нэгэн бидний өмнөөс банканд очоод байшингийн маань лизингийг төлж байгаатай адилхан утгатай. Өөрийнхөө зүйлийг халхалж, барагдуулж байгаа хэрэг биш харин бидний төлөө бидний бурууг халхалж байгаа гэсэн үг юм. Аврагдсаны дараа юу болдгийг ойлгохын тулд бидэнд энэхүү ялгаа маш чухал байх ёстой. Бид гэм нь Бурханаас далдлагдсан нүгэл үйлдэгчид хэвээр байх гэж аврагдаагүй. Харин бид гэмийн дарамт, гэмийн хүчнээс чөлөөлөгдөхийн тулд аврагдсан. Энэ бол бидний зөвхөн төсөөлөлд л байдаг эвлэрүүлэл биш харин бодит байдал юм.

Ойлголт 2: Цэвэршүүлэлт

Бид цусаар угаагдаж, бузар муугаас цэвэрлэгдэж, цэвэр болгогдсон. Сүм доторх тодорхой хэсэг газруудад цус цацах нь Хуучин Гэрээний үеийн эвлэрүүллийн зан үйлд цэвэршүүллийн үйлдэл хэмээн тооцогддог байсан. Шинэ Гэрээнд Еврейчүүдэд хандсан захидлаас харахад цус цэвэр болгодог харин “эвлэрүүллийг” бичээч голчлон угаах, цэвэрлэх гэсэн утгаар ойлгож байсан нь тодорхой байна. Есүс бол илүү сайн тахил, нэг удаа өргөөд мөнхөд тооцогдох тахил, Хуучин Гэрээний үед амьтнаар өргөдөг тахилын бүрэн дүүрэн гүйцэлдүүлж чадаагүйг гүйцээж, гэмээс мөнхөд бүрэн

цэвэрлэж чадсан тахил юм. Эртний нэгэн магтууд “Миний гэмийг юу цэвэрлэж чадах вэ? Есүсийн цуснаас өөр юу ч биш!” гэжээ.

Аврах нигүүлсэл гэмт хир буртаг, бузар мууг маань угааж биднийг Бурханы оршихуйд цэвэрт тооцуулдаг Бурханы хайрын илэрхийлэл билээ. Тийм ч учраас бид баптисмийг шинэ амьдрал уруу хөтөлдөг угаал гэж ойлгодог.

Ойлголт 3: Гэмшил

“Гэмших” гэдэг нь явж байгаа зүг рүүгээ явахаа болиод, зориудаар зүгээ буруулан, бүр эсрэг тийшээ алхах гэсэн утгатай. Өөрөө өөрийнхөө эзэн болсон гэмт чанартай бид өөрийнхөө замыг тодорхойлохдоо Бурханд дуулгаваргүй байх замыг тогтоодог. Өөрсдийн маань зам биднийг үхэлд хүргэнэ гэдэг нь золиос бүхий өргөлийн явцад ойлгомжтой болдог. Энэхүү хариуцлагыг хүлээн зөвшөөрч, бид Бурхан уруу эргэдэг. Үүнийг угтал нигүүлсэл бидэнд боломжтой болгож өгчээ.

Ойлголт 4: Гэрээ

Гэрээ нь Бурхан бидэнтэй байгуулахыг хүсч буй харилцаа юм. Тэгэхээр эвлэрүүлэл бол харилцааны хэл гэсэн үг. Тахил бол бизнесийн гэрээ эсвэл хуулийн хэлцлийн тухай огт биш. Харин нурсан харилцааг сэргээх тухай юм. Аврах нигүүлсэл бол бидний зүгээр л авдаг зүйл биш харин бидэнд хайртай Бурханы үйл ажиллагаа билээ. Биднийг Бүтээгчтэйгээ, бие биетэйгээ, өөртэйгөө болон бүтээгдсэн ертөнцтэй харилцаатай амьдрах арга замыг Бурхан бий болгож өгсөн. Эвлэрүүлэл зөв харилцааг бий болгодог бөгөөд бид эвлэрлийг мэдрэх үед гэрээний итгэмжит, дуулгавартай хамтрагч шиг амар тайван дотор амьдрах болно.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их тунгаан бодоосой гэж хүсэж байна вэ? Бурхан танд юу гэж хэлж байна?

[illegible]

ЗАЛБИРЦГААЯ

Тахилын ойлголтын хүрээнд бидэнд аврах нигүүлслийг өгсөн Бурханд талархъя. Бурхан таны ямар өрийг төлсөн бэ? Бурхан таны амьдралыг ямар хир тортгоос цэвэрлэсэн бэ? Гэмшсэнээр таны амьдралын чиглэл яаж өөрчлөгдсөн бэ? Бурхантай харилцах харилцаа (эсвэл гэрээ) таны хувьд ямар утгатай вэ?

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Еврей 9:13-14 уншаарай. Тахилын тухай хэллэг энэ эшлэлд хэрхэн хэрэглэгдсэн байна вэ?

2. Хэрэв танаас “Есүс яагаад үхэх шаардлагатай байсан бэ?” гэж асуувал та юу гэж хариулах вэ?

3. Гэмийг халхалдаг цусны тухай тайлбарлаж буй энэхүү бүлэг эвлэрүүллийн тухай бодлыг тань өөрчилсөн үү?

4. Аврах нигүүлслийн тухай бодлоо та хэрхэн дүгнэх вэ? Та юу сурсан бэ? Та юунд баярлаж байна?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

АВРАХ НИГҮҮЛСЭЛ

Угтал нигүүлсэлд бууж өгснөөр бид Бурхантай харилцах боломжтой болдог. Хүн гэмээ улайх үед л аврах нигүүлсэл өгөгддөг ба энэ нь сайнмэдээний хамгийн том мэдээ юм. Бурхан бидний төлөө хийсэн зүйлийн тусгал болж, бусдад мөн тэгж хандахад бэлэн байх амьдрал руу Бурханы аврах нигүүлсэл биднийг хөтөлдөг. Бүлэг бүр аврах нигүүлслийн мөн чанарын тухай эргэцүүлэх, тэмдэглэл хөтлөх, залбирах болон жижиг бүлгээрээ ярилцах хэлэлцүүлгийн асуултаар өндөрлөнө.

НИГҮҮЛСЛИЙН АЯНЫ ЦУВРАЛУУД

Ахин дахин үнэгүй өгөгдсөн Бурханы нигүүлсэл нь бүхий л хэлбэрээр бидэнд хэрэгтэй тэрхүү нигүүлсэл мөн. Бидний хэлдгээр, Христэч амьдрал бол нигүүлслээс нигүүлслийн хооронд өрнөдөг. Бурхан бидний замыг маань бэлтгэхийн тулд бидний урд алхдаг. Бурхан биднийг аварч, гэмээс чөлөөлсөн. Тэрээр биднийг ариун байдлын замаар удирдан дагуулдаг. Дөрвөн долоо хоногийн хугацаанд үзэх хичээл тус бүрээр бид Өөрийн хүмүүстээ өгсөн Бурханы олон төрлийн өгөөмөр хайрынх нь талаар илүү гүнзгий судлах бөгөөд ийнхүү бидний итгэлийн амьдрал жинхэнэ Нигүүлслийн Аялал болох болно.

ДЭН БҮҮН нь Трэвэка Назарын Их Сургуулийн (АНУ-ын Нэшвилл дэх) ерөнхийлөгчөөр ажилладаг. Тэрээр Назарын Теологийн Сургууль болон МоКормик Теологийн Сургуульд тус тус суралцан, Дивинити Магистр, Министри Магистрийн зэрэг хамгаалжээ. Бүүн хэд хэдэн шилдэг борлуулалт бүхий номын зохиогч билээ.